

Даалгавар 2: Биеийн хөгжлийн дасгал хийлгэх

Зорилго: 5-6 настай хүүхдийн биеийн хөгжлийн нэг том үзүүлэлт болох "тэнцвэр"-ийг шалгаж, тодруулахад оршино.

Дасгалын төрөл:

- Нэг хөлөө өргөж 30 секунд өрөөсөн хөл дээрээ зогсох;
- Дээсээр 7 удаа нэг ч алдахгүй үсрэх;
- 2 м-ын урттай, 20 см-ын өргөнтэй шулуун замаар ухарч алхах;
- Нүдээ аниад нэг хөл дээрээ 30 секунд зогсох;
- Хөлийн өлмий дээрээ 2м урагш алхах;
- Хөлөө нийлүүлэн салгахгүйгээр байрандаа 10 удаа үсрэх;
- Аяганд ус хийж нэг гарын алган дээр тавьж 2м зайд урагш алхах;
- хөлөө салгаж нийлүүлэн 10 удаа үсрэх

Үнэлгээний аргачлал:

№	Дасгалын төрөл
1	Нэг хөлөө өргөж 30 секунд өрөөсөн хөл дээрээ зогсох;
2	Дээсээр 7 удаа нэг ч алдахгүй үсрэх;
3	2 м-ын урттай, 20 см-ын өргөнтэй шулуун замаар ухарч алхах;
4	Нүдээ аниад нэг хөл дээрээ 30 секунд зогсох;
5	Хөлийн өлмий дээрээ 2м урагш алхах;
6	Хөлөө нийлүүлэн салгахгүйгээр байрандаа 10 удаа үсрэх;
7	Аяганд ус хийж нэг гарын алган дээр тавьж 2м зайд урагш алхах;
8	Хөлөө салгаж нийлүүлэн 10 удаа үсрэх

Даалгавар 3: Хүмүүжил, ёс зүйн төлөвшлийг шалгах

Зорилго: Хүүхдийн хүмүүжил, зан чанар, төлөвшлийг илрүүлэхэд оршино. Ялангуяа ШМС-ийн хувьд, бусдад туслах, талархах сэтгэлийг хүмүүжлийн үндэс гэж үздэг тул хүүхдийн гэр бүлийн суурь хүмүүжлийг харахдаа “тусч сэтгэл”-ийг илрүүлэх нь хамгийн гол шалгуур гэж үзлээ.

Багшийн үйл ажиллагаа: Багш энэхүү асуултыг хүүхдэд тавихдаа эхний хариултаар шууд дүгнэхгүй, дараах шат дараалал бүхий асуултаар хүүхдийн санаа бодлыг аль болох дэлгэрүүлнэ.

- Яагаад?
- Тэгвэл тэр хүн юу гэж бодож байгаа бол?/Эсрэг талын хүний өнцгөөс бодуулах асуулт өгнө/
- “Чиний бодлоор...?” гэх мэт//

Үнэлгээний аргачлал:

- Тусч хүнлэг байдал /Өөрөө санаа бодлоо бусдын тусламжгүй илэрхийлж, тэр явцдаа бусдын төлөө гэх сэтгэлээ илэрхийлж байвал / 7-10 оноо
- Хүнээр хэлүүлээд бусдын талаар бодож эхлэх /Багшийн зүгээс дөхүүлэх асуулт өгсний дараа хүнд туслах сэтгэлээ илэрхийлж байвал/ 4-6 оноо
- Хэт амин хувиа хичээдэг эсэх /хичнээн чиглүүлэх асуулт тавьсан ч бусдын талаар огтхон ч бодохгүй хариултаар өгч байгаа бол.../ 0-3 оноо

Ерөнхий асуултууд:

Асуулт 1. Гадаа маш халуун байлаа. Хүүхдийн парк дээр усан завиар тоглохоор дугаарлан зогсож байв. Гэтэл нэг хүүхэд чамаас урдуураа оруулахыг гуйлаа. Чи яах вэ?

Асуулт 2. Чамайг хүүхэлдэйн кино үзэж байтал аав нь ажлаасаа ирээд зурагтын суваг сольчихов. Чи яах уу?

Асуулт 3. Чи гэртээ дуртай тоглоомоороо тоглож байв. Жаахан дүү чинь тоглоомыг чинь булаацалдан уйлав. Тэгвэл чи яах вэ?

Асуулт 4. Чамайг тоглоомын талбайд тоглож байтал нэг жаахан хүүхэд гүйж байгаад ойчоод уйллаа. Яг энэ үед нөгөө талаас ээж чинь чамайг дуудлаа. Чи одоо яах вэ?

Асуулт 5. Цэцэрлэг дээрээ тоглож байгаад найзыгаа санамсаргүй түлхээд унагаж орхив. Найз нь гомдоод уйлж байна. Гэтэл яг энэ үед ээж нь цэцэрлэгээс чамайг авахаар үүдэнд ирээд дуудаж байна. Чи яах вэ?

Асуулт 6. Ээжүүд маань Тэмүүлэн бид хоёрыг амралтын өдрөөр музей үзүүлэхээр тохирчээ. Музейн үүдэнд найзыгаа хараад шууд л хөөцөлдөж тогломоор санагдлаа. Гэтэл музей дотор ортол музейн тайлбарлагч эгч гүйж болохгүй шүү гэж санууллаа. Чи яах вэ?

Асуулт 7. Чи гэртээ сууж байтал эгч чинь чамд маш гоё амттай зүсэм бялуу авч ирж өглөө. Өмнө харж байгаагүй амттай сайхан бялуу байна. Гэхдээ жоохон хүлээвэл ээж дүү хоёр нь гэртээ ирнэ. Чи яах вэ?

Асуулт 8. Шинэ жилээр өвлийн өвөө бэлэг өглөө. Бэлгэн дотроос гоё гоё цаастай олон чихэр гарч ирлээ. Нэг нэгээр нь чихрээ задалж амтархан идэхдээ цаасаа хөл дороо хаяад л байв. Зурагтаар дуртай хүүхэлдэй маань гарч байна. Гэтэл газраар зөндөө их чихрийн цаас болчихсон байхыг хараад түрүүхэн ээж нь гэрээ цэвэрлэсэн нь санагдлаа... Чи яах вэ?

№	Асуултын агуулга	Жишиг харилцан ярианы хувилбар
1	Гадаа маш халуун байлаа. Хүүхдийн парк дээр усан завиар тоглохоор дугаарлан зогсож байв. Гэтэл нэг хүүхэд чамаас урдаа оруулахыг гуйлаа. Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Урдаа оруулахгүй - Яагаад? - Яагаад гэвэл би өөрөө халууцаж байгаа болохоор - Тэгвэл нөгөө хүүхэд бас халууцаж байгаа болов уу? - Нээрээ бас тийм байх /эсхүл надад хамаагүй/ - Тэр хүүхдийг урдаа оруулчихвал яах бол?
2	Чамайг хүүхэлдэйн кино үзэж байтал аав нь ажлаасаа тарж ирээд зурагтын	<ul style="list-style-type: none"> - Би хүүхэлдэйгээ үзнэ гэж орилно? - Яагаад?

	суваг сольчихов. Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Миний дуртай хүүхэлдэй гарч байсан болохоор/эсхүл "Би чимээгүй өрөөндөө орно"/ - Тэгвэл аав нь бас дуртай нэвтрүүлгээ үзмээр байгаа болов уу? - Тийм байх / эсхүл "мэдэхгүй"/...
3.	Асуулт 3. Чи гэртээ дуртай тоглоомоороо тоглож байв. Жаахан дүү чинь тоглоомыг чинь булаацалдан уйлав. Тэгвэл чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Дүүдээ тоглоомоо өгнө /эсхүл "дүүгээ загнана"/. - Яагаад? - Дүүдээ хайртай болохоор, миний дүү жоохон болохоор/би тоглоомор байгаа болохоор/ - /Дүү нь уйлах юм биш үү?/ -
4	Асуулт 4. Чамайг тоглоомын талбайд тоглож байтал нэг жаахан хүүхэд гүйж байгаад ойчоод уйллаа. Яг энэ үед нөгөө талаас ээж чинь чамайг дуудлаа. Чи одоо яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Би ээж рүүгээ явна - Яагаад? - Яагаад гэвэл би очих ёстой. - Тэр хүүхэд чиний төрсөн дүү байвал яах байсан бэ? - Дүүгээ босгоно. - Тэгвэл дүү шиг нь жоохон хүүхэд бүдэрчихсэн байна тийм ээ? - Би туслах ёстой байх аа... эсхүл мммм - Ээж рүүгээ очихгүй бол яах бол? -
5	Асуулт 5. Цэцэрлэг дээрээ тоглож байгаад найзыгаа санамсаргүй түлхээд унагаж орхив. Найз нь гомдоод уйлж байна. Гэтэл яг энэ үед ээж нь цэцэрлэгээс чамайг авахаар үүдэнд ирээд дуудаж байна. Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Найзаасаа уучлалт гуйж аргадна. /Ээж рүүгээ гүйж очно./ - Яагаад? - Найзыгаа гомдоочихсон болохоор, найз маань уйлж байгаа болохоор/Ээжийгээ санасан болохоор/ - Найз нь яах бол? - Уйлахаа болих байх/Мэдэхгүй, эсхүл харин ээ.../
6	Асуулт 6. Амралтын өдөр Тэмүүлэн найз бид хоёрыг ээжүүд маань музей рүү дагуулж явлаа. Музейн үүдэнд найзыгаа хараад шууд л хөөцөгдөж тоглоомор санагдлаа. Гэтэл музей дотор ортол музейн тайлбарлагч эгч гүйж болохгүй шүү гэж санууллаа. Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Чимээгүй алхана/Гүйнэ/ - Яагаад? - Ээж загнах байх, эсхүл музейн эгч сануулсан болохоор, эсхүл музейд гүйж болохгүй болохоор /Найзтайгаа тоглоомор байгаа болохоор/ - Музейд яагаад гүйж болохгүй вэ?
7	Асуулт 7. Чи гэртээ сууж байтал эгч чинь чамд маш гоё амттай зүсэм бялуу авч ирж өглөө. Өмнө харж байгаагүй амттай сайхан бялуу байна. Гэхдээ жоохон хүлээвэл ээж дүү хоёр нь гэртээ ирнэ. Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Би ганцаараа иднэ. - Яагаад? - Би бялуунд дуртай учраас, эсхүл дэндүү амттай харагдаж байсан болохоор - Ээж дүү хоёр нь бас идэхийг хүсэх болов уу? - Дүү маань ч гэсэн бялуунд дуртай л даа... эсхүл мэдэхгүй...
8	Асуулт 8. Шинэ жилээр өвлийн өвөө бэлэг өглөө. Бэлгэн дотроос гоё гоё цаастай олон чихэр гарч ирлээ. Нэг нэгээр нь чихрээ задалж амтархан идэхдээ цаасаа хөл дороо хаяад л байв. Зурагтаар дуртай хүүхэлдэй маань гарч байна. Гэтэл газраар зөндөө их чихрийн цаас болчихсон байхыг хараад түрүүхэн ээж нь гэрээ цэвэрлэсэн нь санагдлаа... Чи яах вэ?	<ul style="list-style-type: none"> - Цаасаа түүж хогийн саванд хийнэ /Зурагтаа үзнэ/ - Яагаад? - Ээж маань баярлах болохоор, эсхүл хогийн цаасыг гэртээ хаяж болохгүй болохоор /Миний дуртай хүүхэлдэй гарч байгаа болохоор, эсхүл ээж дандаа гэрээ цэвэрлэдэг болохоор, эсхүл манайх гэрийн үйлчлэгчтэй/ - Чи гэртээ дандаа хогоо хогийн саванд хийдэг үү? /Ээж нь чамайг хараад юу гэх бол? Эсхүл ээж нь гэрийн үйлчлэгч эгч нь ядардаг болов уу?/ - Тийм, эсхүл хааяа/Загнах байх...Мэдэхгүй.../

Даалгавар 4: Бүтээлч даалгавар

1. Юүлүүр

Хэрэглэгдэх зүйл: А5 хэмжээтэй бичгийн цаас, цэвэр усны сав, аягатай ус
Хийх ажил: Бичгийн цаасаа ашиглан аягатай усыг цэвэр усны саванд хийнэ.

2. Уут

Хэрэглэгдэх материал: А5 хэмжээтэй бичгийн цаас, элс, бичгийн хавчаар 2 ширхэг
Хийх ажил: Бичгийн цаас, 2 ширхэг бичгийн хавчаарыг ашиглан, элс асгарахааргүй уут хийнэ.

3. Сандал

Хэрэглэгдэх материал: /Холгүйхэн дээр нь сууж болохуйц хогийн савыг хөмөрч тавьсан байна/

Хийх ажил: Багш хүүхдийг гаднаас орж ирэхэд суух даалгавар өгнө.

4. Ус зөөх

Хэрэглэгдэх зүйл: Том хувинтай ус, жижиг сав, ёроолгүй цэвэр усны сав, тухайн савны таг

Хийх ажил: Цэвэр усны сав, таг хоёрыг ашиглан, том хувинтай уснаас жижиг сав руу зөөнө.

5. Хогийн шүүр, тосгуур

Хэрэглэгдэх материал: Хатуу цаас, ундааны таг

Хийх ажил: Цаас, таг хоёрыг ашиглан ширээн дээрх хогийг цэвэрлэнэ.

6. Хэц

Хэрэглэгдэх материал: 2 цэвэр ус, нойтон сальфетка-1, дундуур нь нугалсан зураг

Хийх ажил: 2 Цэвэр ус, сальфеткийг хэрэглэн зургийг өлгөнө.

7. Савх

Хэрэглэгдэх материал: Савх мод-1 ширхэг, базсан цаас

Хийх ажил: Савх модыг ашиглан базсан цаасыг зөөж тавина.

8. Гол цэг

Хэрэглэгдэх материал: Хуудас цаас, харандаа

Хийх ажил: Цаасны голыг олж цэгээр тэмдэглэх